



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 48

Номгон

Эзэмшил газар шилжүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 62.2, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “а”, “в”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалт, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 40 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах журам”-ын 1.3, 5.1 дэх заалтуудыг үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Баянхонгор сумын 1, 4 дүгээр багийн өрхийн эмнэлгийн барилга нь Оточмандал өрхийн эрүүл мэндийн төвд бүртгэлтэй тул барилгын доорх газар болох Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газарт 2014 онд олгосон Номгон 1 дүгээр багийн нутаг Номгон сургуулийн хичээлийн 2 дугаар байрны ар талд байрлалтай 600м² талбай бүхий газрыг Оточмандал өрхийн эрүүл мэндийн төвд шилжүүлсүгэй.

2. Газар эзэмших гэрчилгээг барилга эзэмшигч Оточмандал өрхийн эрүүл мэндийн төвд шилжүүлэхийг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

3. Газрыг байгууллагын нэр дээр шилжүүлэн авч, газар эзэмших гэрчилгээг Улсын бүртгэлд бүртгүүлж, зориулалтын дагуу эзэмшихийг Оточмандал өрхийн эрүүл мэндийн төвийн дарга /С.Лхамдулам/-д үүрэг болгосугай.

4. Байгууллагын эзэмшил газрыг “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэж, хэрэгжилтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар үүрэг болгосугай.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д даалгасугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

